



ДОРНОД АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН
ГАЗАР

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025

МОНГОЛ ХЭЛ

Онлайн сорил-1

12 сарын 21 14.00-15.20

Санамж:

1. Эхийг анхааралтай уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.
2. Асуулт даалгавар бүрийг дуустал уншиж ойлгоорой.
3. 1-17 дугаар сорилыг эхийн утга санаатай холбож ажиллаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

(Даалгавар бүр 2 оноотой)

ТАЛ

Тал хязгааргүй хөхөртөн мануурна. Эхлэл нь хaa юм, төгсгөл нь хaa ч юм. Ташуухан гийх өглөөн нарны тунгалаг туяа ээвэр хондонд хаваржиж бүхий хот айлыг гийгүүлнэ. Малын уур униартай нийлэлдэн, гарын алга шиг хонхор газарт бялхсан туян дундаас цэв цэнхэр багана ганжирлан, тэнгэр тулах нь гэрийн утаа буюу сайхан өдөр болох нь ээ.

Тал хязгааргүй ногоорон мануурна. Эхлэл нь хaa юм, төгсгөл нь хaa ч юм. Жин үдийн нар цэцгийн гэсэр, өвсний үзүүр бүхнийг чанх дээрээс нь алаггүй гийгүүлж, улайдсан чулуу ухаа ягаанаар минчийлдэх агаад гагцхүү худгийн хүйтэн усанд ширэн ховоо л нэг гал халууныг эс ажран буй за.

Тал хязгааргүй ухааран мануурна. Эхлэл нь хaa юм, төгсгөл нь хaa ч юм. Үдшийн тэнгэр тэгнүүрдэн бүхий шар дэнж дээгүүр хэсэг адuu дэргэн айсуй бөгөөд олон малын хөлд гишгэгдсэн таанын аагь талын тэнгэрийг согттол анхилах нь нэн таатай.

Тал хязгааргүй цайвалзан мануурна. Эхлэл нь хaa юм, төгсгөл нь хaa ч юм. Одод тэнгэртээ жирвэгнэлдэж, цасны илтэс басхүү одны туяанд гялтганана. Битүү цагаан тал шөнөөр ч өөрөөсөө гэгээ татуулан, өвсний толгойд цан молцоглож, цэцгийн дэлбээ талстан бурзайжээ. Морин туурай шажиг шужиг гэн, мөнөөх талын хүний танил дуу аниргүй шөнийн харанхуйг алгуураар дүүргэн сүлж айсуй.

Г. Мэнд - Ооёо

1.

Үгийн утгыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

- | | | |
|-------------------|---------------------------------------|-------------------|
| 1. мануурна | a. цэцгийн доторх үс мэт юм | |
| 2. хонд | b. тэнгэр нүсэр харагдах байдал | |
| 3. гэсэр | c. бог мал зэргийг арчлах бууц хэвтэр | |
| 4. тэгнүүрдэн | d. униар будан дунд үргэлжлэн манаах | |
| A. 1c, 2d, 3b, 4a | B. 1d, 2a, 3c, 4b | C. 1d, 2c, 3a, 4b |
| D. 1a, 2b, 3c, 4d | E. 1b, 2a, 3d, 4c | |

2.

Цогцолборуудыг өнгөөр зөв дараалуулсныг сонгоорой.

- A. цайвардуу, хөхөвтөр, улаавтар, ногоондуу
- B. хөх, ногоон, ухаа, цайвар
- C. цэнхэр, улаан, ногоон, цагаан
- D. боровтор, ногоон, шар, цайвардуу
- E. цайвалзсан, хөхөрсөн, ногоорсон, ухаарсан

3.

Эхийн цаг хугацааны уялдаа холбоог олоорой.

- A. шөнөөр ч гэгээ татуулан, үдшийн тэнгэр, өглөөн нар, үдшийн тэнгэр
- B. өглөөн нар, жин үдийн нар, үдшийн тэнгэр, одод жирвэгнэлдэж
- C. өглөөн нар, үдшийн тэнгэр, жин үдийн нар, одод жирвэгнэлдэж
- D. өглөөн нар, жин үдийн нар, үдшийн тэнгэр, шөнөөр ч гэгээ татуулан
- E. шөнөөр ч гэгээ татуулан, жин үдийн нар, өглөөн нар

4.

Эхийн сэдвийг түлхүүр үгсээр зөв тодорхойлсныг олоорой.

- A. тал, хөхөртөн, ногоорон, ухааран, цайвалзан, утаа, ховоо, адуу, хүн - улирал ба ахуй
- B. тал, ухааран, ногоорон, хөхөртөн, цайвалзан, адуу, ус, илтэс - улирал ба хүн
- C. эхлэл, хөхөртөн, ногоорон, ухааран, мануурна, чулuu, гэсэр, адуу - улирал ба мал
- D. хавар, өвөл, хот айл, өвс, багана, нар, одод, аагь, туурай - эхлэл ба төгсгөл
- E. хавар, зун, одод, адуу, гэгээ, илтэс, хүн, гэгээ, цан - төгсгөл ба өвөл

5.

- . Эхийн сэдвээс гол санааг зөв дүгнэснийг сонгоорой.
- A. Хүний амьдралын чөлөө учрал дахь бясалгал
 - B. Дөрвөн улирлын жам болоод тал нутгийн дүрслэл
 - C. Хүний гадаад, дотоод шинжийг дүрсэлсэн хөрөглөл
 - D. Төрөх, үхэх нь үнэн гэсэн амьдралын жам ёсны илэрхийлэл
 - E. Дөрвөн цагийн эргэлт болоод тал нутгийн ахуйн зураглал

6.

- “гийгүүлнэ, бялхсан, ганжиран, тэгнүүрдэн, анхилах нь, гялтганана, гэгээ татуулан” гэсэн үгс эхийн найруулгад ямар өнгө аяс илэрхийлж байна вэ?
- A. санан дурссан
 - B. энгийн ерийн
 - C. эгэл даруухан
 - D. эрхэмсэг тансаг
 - E. гэгээн, гуниглуун

7.

- Тонгоргох хувиргалаар бүтсэнийг олоорой.
- A. ташуухан гийх
 - B. хөлд гишгэгдэх
 - C. улайдсан чулуу
 - D. эс ажрах буй за
 - E. тэнгэр тулах нь

8.

“Одод тэнгэртээ жирвэгнэлдэж, часны илтэс басхүү одны тuyaнд гялтганана” гэсэн өгүүлбэрээс “од”-той уялдах утgyн холбоог зөв тогтоосныг олоорой.

- A. тэнгэртээ жирвэгнэлдэж, илтэс гялтганана
- B. одод жирвэгнэлдэж, часны илтэс гялтганана
- C. одод жирвэгнэлдэж, басхүү гялтганана
- D. одод жирвэгнэлдэж, одны тuyaнд гялтганана
- E. одод гялтганаж, одод жирвэгнэлдэнэ

9.

Холимог нийлмэл өгүүлбэр дэх “туяа” гэсэн үгийг тодотгон дэлгэрүүлсэн гишүүн өгүүлбэрийг олоорой.

Малын уур униартай нийлэлдэн, гарын алга шиг хонхор газарт бялхсан тuyaн дундаас цэв цэнхэр багана ганжирлан, тэнгэр тулах нь гэрийн утаа буюу сайхан өдөр болох нь ээ.

- A. малын уур униартай нийлэлдэн
- B. гарын алга шиг хонхор газарт бялхсан
- C. тэнгэр тулах нь гэрийн утаа
- D. сайхан өдөр болох нь ээ
- E. цэв цэнхэр багана ганжирлан

10.

Онцолсон өгүүлбэрүүд утгын ямар харьцаанд байна вэ?

Жин үдийн нар цэцгийн гэсэр, өвсний үзүүр бүхнийг чанх дээрээс нь алаггүй гийгүүлж, улайдсан чулуу **ухаа ягаанаар минчийлдэх** агаад гагцхүү худгийн хүйтэн усанд ширэн ховоо л нэг гал халууныг эс ажран буй за.

- A. “жин үд”, “chanх дээрээс” гэх үгс нь орны утга илтгэх тул ойролцоо утгатай
- B. “ухаа ягаан”, “гал халуун” гэх үгс нь шинжийг илтгэж байгаа учраас ойролцоо утгатай
- C. “чулуу”, “ховоо” гэх үгс нь эд юмсыг нэрлэж байгаа учир зүйлчилсэн утгатай
- D. “минчийлдэх” нь халуун, “эс ажран буй за” нь хүйтэн гэсэн утга илтгэх тул эсрэг утгатай
- E. “цэцгийн гэсэр”, “өвсний үзүүр” гэх үгс нь бүхлийн хэсэг тул төсөөт утгатай



11.

“тэнгэр согттол анхилах” гэсэн дүрслэлийн далдалсан утгыг зөв тайлсныг сонгоорой.

- A. монголчууд шүтлэгтэй учир “тэнгэр”-ийг дээр оршин байдаг гэсэн утгаар нь бэлгэдсэн бэлгэдэл
- B. малын хөлд гишгэгдэж бяцарсан тааны аагь нь илүү их үнэртэхийг амьдчилан тойруулсан
- C. “анхилах” гэдэг үйлийг товоилгон тодруулах зорилгоор “согтох” гэдэг үгэнд утга шилжүүлэн адилтгасан адилтгал
- D. “согттол анхилах” гэсэн үйлийг эсрэг утгаар илэрхийлж, шүүмжилсэн тул егөөдөл
- E. “тэнгэр” гэдэг үгийн том их гэсэн утгыг илрүүлэх зорилгоор “согтох” гэдэг үгээр шилжүүлсэн нь багасгал

12.

“гарын алга шиг хонхор газарт” гэсэн адилтгал ямар утга илтгэж байна вэ?

- A. цагийн утга
- B. орны утга
- C. шалтгааны утга
- D. зорилгын утга
- E. болзлын утга

13.

“молцоглох” гэсэн үг эхэд ямар утгаар орсон бэ?

- A. нэг хэсэг нь цухуйн харагдах
- B. юманд мөгий мэт мушгиран тогтох
- C. модонд асаж сагсайн ургах
- D. өвс ургамалд наалдан ширэлдэх
- E. бөөрөнхий хэлбэртэй болж зүүгдэн хөлдөх

14.

“таанын аагь талын тэнгэрийг согттол **анхилах нь** нэн таатай” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг “үнэртэх нь” хэмээх үгээр соливол найруулгад ямар өөрчлөлт гарах вэ?

- A. дээд найруулгын зэрэг хэвээр байна
- B. хүндэтгэлийн утгатай болно
- C. найруулгад өөрчлөлт орохгүй
- D. доод найруулгын зэрэгтэй болно
- E. найруулгын ерийн зэрэгтэй болно

15.

“жин үдийн” хэмээх үгийн утyg зөв тайлбарласныг олоорой.

- A. бага үд, их үдийн хоорондох хугацаа
- B. бага үд болж байгаа хугацаа
- C. их үд болж байгаа хугацаа
- D. их үдээс хойших хугацаа
- E. бага үдээс өмнөх хугацаа

16.

“тал шөнөөр ч өөрөөсөө **гэгээ** татуулан” гэснээс онцолсон үгийн тэг бүтээврийг олоорой.

A. -ын

B. -ийг

C. -ыг

D. -г

E. -ийн

17.

“шөнийн харанхуйг алгуураар дүүргэн сүлж айсүй” гэснээс онцолсныг соливол аль нь тохирох вэ?

A. -вч

B. -вөл

C. -сээр

D. -лгүй

E. -сэн

18.

Утгаараа тохирохыг сонгоорой.

..... хүн эхийгээ ч эс хайрлана, юуг ч эс хайрлана.

A. Эх орноо хайламагц

B. Эх орноо эс хайрласан

C. Эх орноо хайрласан

D. Эх орноо эс мартсан

E. Эх орноо хайллахад

19.

“бүтэхгүй, болохгүй” гэсэн утгатай хэлцийг үг нөхөж бүтээгээрэй.

Харганы түүж эсгий хийх

A. саваг

B. ноолуур

C. унгас

D. хөөвөр

E. дэл

20.

Тохирохыг сонгож нөхөөрэй.

Айхавтар..... ах дүү нар байлаа

Адалж, хүмүүс тэднийг Харамчийнхан гэдэг байлаа

- A. гар сайтай
- B. гар чангатай
- C. гар султай
- D. гар зөөлөнтэй
- E. гарын дүйтэй

21.

Таслал зөв хэрэглэснийг олоорой.

- | | |
|--|---------------------------------------|
| A. Өчигдөр, таны авчирсан номыг уншив. | B. Өчигдөр таны авчирсан, номыг уншив |
| C. Өчигдөр таны авчирсан номыг, уншив. | D. Өчигдөр таны, авчирсан номыг уншив |
| E. Өчигдөр таны номыг, уншив. | |

22.

“оно+ш+л+гоо” гэснийг зөв залган бичсэнийг олоорой

- | | | |
|--------------|--------------|--------------|
| A. оношилгоо | B. оношлогоо | C. оношолгоо |
| D. оншилгоо | E. оношил | |

23.

“Харьяалахын тийн ялгалын “-н” нөхцөлийг хос эгшгээр төгссөн үгэнд залгана” гэсэн дүрэмд тохирохыг олоорой.

- | | | |
|-------------------|-----------------|--------------|
| A. аргын тоолол | B. ухааны цараа | C. соёлын өв |
| D. талбайн хэмжээ | E. өглөөн нар | |

24.

“бод” язгуураас бүгд үг бүтээх дагавартай хэсгийг сонгоорой.

- | | | |
|-----------------------|-------------------------|-------------------------|
| A. -л, -лого, -в, -ын | B. -л, -лого, -лт, -оод | C. -л, -сон, -лт, -лого |
| D. -л, -лого, -в, -мж | E. -л, -лого, -лт, -мж | |

25.

“Би үзнэ ч, очно ч” гэснээс онцолсон баймж бүтээврийн утгад тохирохыг олоорой.

- | | | |
|-----------------------|-----------------------|------------------|
| A. ялган онцлох | B. эсрэгцүүлэн онцлох | C. онцлон батлах |
| D. зэрэгцүүлэн онцлох | E. багасган адилтгах | |

26.

Ж.Саруулбуян “Бодончар богд” өгүүллэгтээ “Тэр урагт үл тооцогдон ах нартаа адлагдан хөөгдсөндөө нэг их гутарсан ч үгүй. Харин ч ухаан тэлүүлж, нэгийг бодон хоёрыг эргэцүүлэх хугацаатай боллоо гэж тайвширна” гэж өгүүлжээ. Онцолсон хэллэгт дүйх утгатай /Монголын нууц товчоо/-г сонгоорой.

- A. гол дайрт, годил сүүлт орогшинхул морио унав
- B. тэр урагт эс тооцогдсон
- C. үхвэл үхье, амьдарвал амьдаръя даа
- D. хар хур шувууг бор харцага барьж идэхийг үзэв
- E. мөчир бүрээс мөч гуя өлгөв

27.

Үг сонгож, тодорхойлолтыг гүйцээгээрэй

..... гол баатруудынхаа аж амьдралын аль нэг үеийг өгүүлдэг бөгөөд үйл явдал нь романтай адил олон салбарлаж биш дан өгүүлэмжтэй, гол дүрийн явдал нь бусад дүрийн явдалд захирагдмал шинжтэй байдаг.

- A. өгүүллэгт
- B. романнд
- C. жүжигт
- D. туужид
- E. яруу найргийн зохиолд

28.

Зохиолын үйл явдал өрнөсөн цаг үеийг олоорой.

Хичээлийн байрны цагаан ханан дээр сурагчдын дүрэм, **пионерын** тангаргийг алтан үсгээр хичээнгүйлэн бичээд, самбарын дээд талд **Лениний зургийг** хадаж дор нь “Сур сур бас дахин сур” гэж хооронд нь таслал тавин бичжээ.

(П.Лувсанцэрэн “Усны эргүүлэг буюу Борзооны явдал” түүжаас)

- A. ардчилсан хувьсгалын үе
- B. манжийн дарлалын үе
- C. эрх чөлөөний хөдөлгөөний үе
- D. ардын хувьсгалын үе
- E. социалист нийгмийн үе

29.

. Д. Мягмарын “Үер” туужийн эшлэл дэх онцолсон дүрслэлийн бэлгэдэл юу вэ?

...Залуу эцэг хүүгээ тэвэрсэн хэвээр завинаас үсрэн бууж өвгөний дэргэд харайлган хүрээд босгох гэж өрөөсөн гараараа өргөхөд нялх **хүүхдийн часхийх дуу** дахин хадав.

- A. амьдрал мөнхөд тасралтгүй үргэлжлэх
- B. удам тасралгүй үргэлжлэх
- C. амьдралын зам шулуун байх
- D. амьдралын зам сайхан байх
- E. хугацаа мөнхөд үргэлжлэх

30.

. “Нарангэрэл дагины тууж”-ийн сэдэв, утга санаатай холбон хам сэдвийг олоорой.

Сэдэв	Утга санаа
Нигүүлсэнгүй сэтгэлийн тухай	Бусдыг хайрлах, энэрэх нь өөрийн бие сэтгэлийн зовлонгоос хүчтэй

- A. гүн ухааны
- B. соёлын
- C. түүхийн
- D. нийгмийн
- E. улс төрийн

31.

. Өгүүлбэрийг уншаад, онцолсон үгийн утгад тохирохыг сонгоорой.

А. Түүхийн
Б. Түүхийн
В. Түүхийн

Г. Түүхийн
Д. Түүхийн
Е. Түүхийн

Ж. Түүхийн
З. Түүхийн
И. Түүхийн

A.

B.

C.

D.

E.

Л. Түүхийн
М. Түүхийн
Н. Түүхийн

О. Түүхийн
П. Түүхийн
Р. Түүхийн

С. Түүхийн
Т. Түүхийн
У. Түүхийн

Х. Түүхийн
Ү. Түүхийн
Ч. Түүхийн

Д. Түүхийн
Е. Түүхийн
Ж. Түүхийн

32.

. “” гэсэнд тохирохыг нөхөөрэй.

A. Үүхийн
Б. Түүхийн
В. Түүхийн

Г. Түүхийн
Д. Түүхийн
Е. Түүхийн

Ж. Түүхийн
З. Түүхийн
И. Түүхийн

Л. Түүхийн
М. Түүхийн
Н. Түүхийн

О. Түүхийн
П. Түүхийн
Р. Түүхийн

33.

Зөв харгалзуулсныг олоорой.

1. ~~Хүлэг~~

a. хөлөг онгоц

2. ~~Хүлэг~~

b. хүлэг морь

3. ~~Хүлэг~~

c. уяа хүлэг

A. 1b, 2c, 3a

B. 1a, 2b, 3c

C. 1b, 2a, 3c

D. 1c, 2a, 3b

E. 1c, 2b, 3a

34.

“Үгийн үндэс нь “л” гийгүүлэгчээр төгсөж, нөхцөл нь хувилгагч үсгээр эхэлж байгаа учир “у”-аар холбоно” гэсэн дүрмээр бичихийг сонгоорой.

A.



B.



C.



D.



E.



35.

“**НОМОО** уншъя” гэсний онцолсон үгийн тэг бүтээврийг олоорой

- A. B. C. D. E.

ণ ՚ ፩ ՚ ፩

36.

“**ӨМӨӨ ӨМӨӨ**” гэснийг уншаарай.

- A. элс авах B. ивээс авах C. өвс авна уу D. өвс авах E. өвс авав

37.

“**ХУВ ӨӨЛН**” онцолсон үгийг зөв таниарай.

- A. хув B. ухаа C. хувь D. хуваа E. хоёр

38.

Зарим гадаад үгийн “у” үсгийг монгол бичигт “ү”-ээр бичдэг зүй тогтоор “вирус” гэсэн үгийг зөв бичсэнийг олоорой.


- A. B. C. D. E.

ᠤ ᠤ ᠤ ᠤ ᠤ


39.

“гийгүүлэгч+эгшиг”-ээс бүтсэн бүтээврийг сонгоорой.


A.




B.




C.



D.



E.




40.

Зөв харгалзуулсныг олоорой.

1. 2. 3.

- a. суу ухаан
- b. сүрэг хонь
- c. сүхний ир



- A. 1a, 2c, 3b
- B. 1b, 2a, 3c
- C. 1b, 2c, 3a
- D. 1c, 2a, 3b
- E. 1c, 2b, 3a

. Уншаад зөв харгалзуулаарай.

- a. b. c. d. e.

жүүхдээс
мийн
хийн
шалтгаалсан
түүхэн

1. 2. 3. 4. 5.

Сүм түм сүүдээ түм шүүдээ
бодшиг түм түүдээсээ сүүдээ
бодшиг түм түүдээсээ сүүдээ
бодшиг түм түүдээсээ сүүдээ
бодшиг түм түүдээсээ сүүдээ

2.2

. Нэг төрлийн дүрэмд хамаарахыг харгалзуулна уу.

- | | |
|------------------------|-------------------|
| a. хүсье, очьё | 1. авч, өгч |
| b. номло, савла | 2. сольж, горьгүй |
| c. хоногийн, самбараар | 3. тусал, цүнхэл |
| d. сорил, захидал | 4. шатрыг, үзгээр |
| e. хүсэж, нотолж | 5. таая, сойё |

2.3

. Онцолсон хэлцийг утгатай нь зөв харгалзуулаарай.

- | | |
|--|----------------------|
| a. Хөөрхий эд чинь сайхан сэтгэлтэй, элэг нимгэнтэй улс юм. | 1. Шалтгааны утга |
| b. Ээж минь намайг алган дээрээ бөмбөрүүлэн өсгөсөн болохоор ачийг нь яаж хариулна даа гэж бодно. | 2. Шинжийн утга |
| c. Энэ бүхэн алга урвуулахын хооронд л болсон доо. | 3. Үйлийн дүр байдал |
| d. Ус балгасан юм шиг дуугүй өөрийгөө зовоож явснаас сэтгэлээ нээгээд авбал дээр дээ. | 4. Цагийн утга |
| e. ...Содном хөл алдан тарган мах чанав. | 5. Орны утга |

Зохиолын эшлэлийг онцлог шинжтэй нь зөв харгалзуулна уу.

- a. Ерөн есөн жилийн тэртээ газарт байдаг
Айхан тохой нутагтай
Алаг уулан түшлэгтэй
Сүн далай нутагтай
Сүмбэр уулан түшлэгтэй
Хөвчин тал нутагтай
Хөх уулан түшлэгтэй...
- b. **Баруун талыг** нь
Барин түшин гарвал даа
Бар, ирвэс, баавгай, шилүүс нь
Бархиралдан ноцолдоод л
Зүүхэн талыг нь
Барин түшин гарвал даа...
- c. Яруу алдар, есөн хүсэл
Өсөх нас, өрнөх буян
Суух заяа, сурх эрдэм
Баярлах наадам, бахтай жаргал
Нас сүүдрээр урт
Найр цэнгэлээр их...
- d. Эх болсон нутгаа сүүлчийн удаа
Хардаг юм гэнэ лээ.
Өндөр оргилоос эвэр нь дийлээд
Хальдаг юм гэнэ лээ.
Өнгөт орчлонгоос нэг нь тэгээд
Дутдаг юм гэнэ лээ! ...
- e. Өдөр явсан явдлыг шөнө **шүүгтүн**
Ичгүүр гэмт явдлыг ятгаж **орхигтун**
Олны дотор үгээ **бэхэл**
Ганцаар суухдаа сэтгэлээ **шинжил**
Олон хүмүн лүгээ найран зохилдож
Ер авах гээхийн ялгалыг **шинжлэн мэд...**
- 1. Баатар нь зайлшгүй шаардлагаар эмгэнэлт явдал, аюул гамшигийг сөрөн босох ч тэрхүү зорилгоо биелүүлэх бололцоогүй.
- 2. Хүний жаргалант сайхан амьдрал, ирээдүйг зөгнөн бэлгэдэж, хүн олны аз жаргалтай амьдрах хүсэл мөрөөдөл биелэхийг хүссэн агуулгатай.
- 3. Ертөнцийн дөрвөн зүг, найман зовхисоос харж буй байдлаар дүрслэн, үзэмжийг магтсан агуулгатай.
- 4. Гол баатрын үйл хэрэгт төвлөрсөн асар уудам олон хэмжээст орон зай, сансар отторгуй, тулаан, урт удаан аялал, ер бусын онцгой баатар, юмс бүтээсэн байдаг.
- 5. Хүний оршихуйн учрыг ухуулах ухааруулах, сургамжлах үүрэг зорилго бүхий ач холбогдолтой.

№	ЗӨВХ ХАРИУ	ОНОО
1	C	2
2	B	2
3	D	2
4	A	2
5	E	2
6	D	2
7	C	2
8	D	2
9	B	2
10	D	2
11	B	2
12	B	2
13	E	2
14	E	2
15	A	2
16	D	2
17	C	2
18	B	2
19	C	2
20	B	2
21	A	2
22	A	2
23	D	2
24	E	2
25	D	2
26	C	2
27	D	2
28	E	2
29	A	2
30	D	2

№	ЗӨВХ ХАРИУ	ОНОО
31	C	2
32	B	2
33	A	2
34	E	2
35	D	2
36	D	2
37	B	2
38	D	2
39	A	2
40	C	2
2.1	a3	1
	b1	1
	c5	1
	d4	1
	e2	1
2.2	a5	1
	b3	1
	c4	1
	d2	1
	e1	1
2.3	a2	1
	b5	1
	c4	1
	d3	1
	e1	1
2.4	a4	1
	b3	1
	c2	1
	d1	1
	e5	1